



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№36 /250/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.02.22

Цаг үе, үйл явдал

ЭНЭ УДААГИЙН ГАРДАН ТУЛААНЫ ТЭМЦЭЭНД ЭМЭГТЭЙ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ОРОЛЦОЖ БАЙНА

Зэвсэгт хүчний 2022 оны аварга шалгаруулах гардан тулаан, орс таталтын тэмцээн өнөөдөр эхэллээ. Нээлтийн ажиллагаанд ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, АУГ-ын дарга бригадын генерал С.Дашзэвэг, Тусгай хүчний цэргийн штабын дарга хошууч генерал Л.Гансэлэм, ҮБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан болон Зэвсэгт хүчний нэгтгэл ангиудын захирагч, тэмцээний шүүгч, баг тамирчид оролцлоо.

ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг тэмцээнийг нээж үг хэлээд баг, тамирчдад баяр хүргэв. Мөн Монгол Улсаас Бүгд найрамдах Казакстан улсад суугаа элчин сайдын яамны цэрэг-агаарын атташе, Зэвсэгт хүчний Гардан тулааны холбооны тэргүүн, ОУХМ, хурандаа Б.Дамба цахимаар мэндчилгээ дэвшүүлсэн юм. Энэ үеэр "Олон улсын цэргийн наадам-2021" тэмцээний "Аравт" морин цэргийн уралдаан, "Танкийн биатлон", "Цэргийн авто ралли" уралдаанд амжилттай оролцсон баг тамирчид болон Цэрэгжлийн спортын цол зэргийн болзол хангасан тамирчдад шагналыг нь гардуулан өглөө. Үргэлжлүүлэн Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн дэргэдэх хүүхэд залуучуудын "Десант бамбар" клубын бяцхан тамирчид, Улаанбаатар цэргийн хүрээний эмэгтэй цэргийн алба хаагчид гардан тулааны үзүүлэх тоглолт толилуулсан юм.

Тэмцээнд 30 гаруй ангийн 400 орчим тамирчин авхаалж, самбаагаа сорьж байна. 1992 оноос хойш зохион байгуулагдаж ирсэн уламжлалтай тус тэмцээн өргөжин тэлсээр баг тамирчид 6 жинд өрсөлддөг болсон. Тэгвэл энэ удаад анх удаа эмэгтэй цэргийн алба хаагчид оролцож 60, 70 кг-ийн жинд өрсөлдөж байгаагаараа онцлог аж.



Түүхэнд энэ өдөр

1921 он

Богд Жавжундамбыг хаан ширээнд өргөмжлөв.

1936 он.

БНМАУ-ын СнЗ-ийн 107 дугаар тогтоолоор Цэрэг ба НАХХЭЯ-ны дэргэд БНМАУ-ын Агаарын харилцааны газрыг байгуулав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-9	-29

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
32	22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,867.00	2,869.0
EUR	3,250.0	3,262.0
CNY	453.00	454.00
RUB	37.30	38.30
JPY	24.80	24.95
KRW	2.39	2.40

ОЮУТАН ЦЭРГИЙН БҮРТГЭЛИЙГ "E-MONGOLIA"-ААР АВНА

БХЯ Боловсрол, шинжлэх ухааны яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран "Оюутан цэрэг" хөтөлбөрийн бүртгэлийг цахимаар буюу "e-mongolia"-аар ирэх сарын 1-10-ны өдрүүдэд явагдах боллоо.

Өмнө нь тухайн оюутан сургуулийнхаа сургалтын албанаас голч дүнг баталгаажуулсан хуулбар, бусад баримт бичгүүдийг авч, дүүргийнхээ Цэргийн штабт өгч бүртгүүлдэг. Тэгвэл "e-mongolia" цахим платформыг ашиглан ердөө тавхан минутын дотор бүртгүүлэх боломжтой болжээ.

Энэ тухай БХЯ-ны СБТГ-ын ахлах мэргэжилтэн хурандаа



ОНЦЛОХ ҮЙЛЧИЛГЭЭ

ОЮУТАН ЦЭРГИЙН БҮРТГЭЛ

2022.03.01 - 2022.03.10

С.Рагчаадорж хэлэхдээ "Тухайн хүсэлт илгээсэн оюутны сурч буй сургууль, сурлагын талаарх мэдээлэл нь БШУЯ-ны дата сангаас тэр даруйдаа баталгаажна. Гэхдээ энэ жил элсэгчдийн тоо хязгаартай байгаа тул хүсэлт илгээсэн оюутан бүрийг тус хөтөлбөрт хамрагдуулж чадахгүй гэдгийг ойлгох хэрэгтэй" гэв. БХЯ-ны зүгээс энэ жилийн цэргийн бүртгэлийг цахимаар 1 дүгээр сард явуулж, 100,000 гаруй иргэнийг бүртгэжээ. Иймд тус хөтөлбөрийг ч мөн цахимаар явуулах боломжтой гэдгийг харсан гэж албаныхан онцолж байлаа.

ЗУРХАЙ

2022.02.22 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЫН 21/

ХАВРЫН ТЭРГҮҮН ХАР БАР САРЫНТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өлсөж ундаасна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.48-18.23

Барилдлага:

Үл зохилдох

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

САНСАР

Суудал: Шороо

Энэ өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сүм дуганыг сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээхэд муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ДОРНЫН ЗУРХАЙ:

Энэ өдөр үхэр, тахиа жилтнээ ЭЕРЭГ сайн

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,270,897 /69.8%!	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,172,253 /66.8%!	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,018,527 31,0% 92,163 /3,0%!
НИЙТ БАТЛАГДСАН 8208 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 59	ЭДГЭРСЭН 8030

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 425,084,678

Эдгэрсэн

Нийт: 350,827,623

Нас барсан

Нийт: 5,906,564

Цахим шууданд

НӨХӨРСӨГ УУЛЗАЛТ ӨДӨРЛӨГ БОЛОВ



Удирдлага, төлөвлөлтийн дарга хурандаа Б.Энхзоргол, Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Ө.Ган-Өлзий болон дээрх байгууллагуудын удирдлага, хамт олон идэвхтэй оролцлоо.

Өдөрлөгийн хүрээнд тэд ширээний теннис, гар бөмбөг, сагсан бөмбөг, биллиард зэрэг спортын төрлүүдээр өрсөлдсөнөөс гадна караоке дууны тэмцээнийг ч зохион байгуулж авьяас билгээ уралдуулсан юм.

Мөн энэ үеэр хоёр байгууллагын удирдлага 2022 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөнд харилцан гарын үсэг зурлаа. Уг төлөвлөгөөнд Агаарын цэргийн анги, салбарын залуу гэр бүлийг төлөвшүүлэх, хөгжүүлэх, тэдний хүүхдүүдийг сургаж хүмүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн хангалтыг дээшлүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэхэд чиглэсэн олон ажил, арга хэмжээ тусгагдсан ажээ.

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, Нийслэлийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын бие бүрэлдэхүүний дунд нөхөрсөг уулзалт өдөрлөг, спортын цогцолбор тэмцээн болов.

Хоёр байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх, алба хаагчдын дунд хамт олонч, нөхөрсөг харилцааг төлөвшүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэж, бие бялдраа чийрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгыг агуулсан эл өдөрлөгт Зэвсэгт хүчний Агаарын цэргийн



Монгол цэрэг энхийн үйлсэд

ТАНЫ СОНОРТ

Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойд зориулсан бэлэг дурсгалын багцыг та бүхэнд танилцуулж байна. Эдгээр багц бэлэг дурсгалын зүйлсийг чанартай, тогтоосон хугацаанд сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойд зориулсан бэлэг дурсгалын зүйлсийг захиалах цэргийн алба хаагчид нэгтгэл, анги, байгууллага саналаа төрлийн цэргийн командлал, газар, хэлтсээрээ дамжуулан ЭХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын энхийг дэмжих ажиллагааны хэлтэст ирүүлнэ үү.

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, Нийслэлийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын бие бүрэлдэхүүний дунд нөхөрсөг уулзалт өдөрлөг, спортын цогцолбор тэмцээн болов.

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, Нийслэлийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын бие бүрэлдэхүүний дунд нөхөрсөг уулзалт өдөрлөг, спортын цогцолбор тэмцээн болов.

Дурсгалын ойн медаллион



Медаллион дээрх дүрслэгдсэн бичиглэл, 20 жилийн ойн лого нарийн тод дүрслэгдсэн, медалионы ард хэсэгт НҮБ-ын цэргийн ажиглагч офицер, цэргийн багийн алба хаагч, эмэгтэй энхийг сахиулагчдын дүрслэл бүхий зураглалыг байршуулсан, 5см диаметртэй

Дэвтэр /стикертэй/



Нүүрэн хэсэгт ойн лого, "Энхийн үйлсэд 20 жил" гэсэн бичиглэлтэй, эко бор цаасан материал бүхий дэвтэр

Дурсгалын таваг



Түлхүүрийн оосор

Дурсгалын тавгийн гол хэсэгт 20 жилийн ойн лого, тойрог хэлбэрээр Монгол Улсын Зэвсэгт хүчнээс үүрэг гүйцэтгэсэн орнуудын газрын зураг, далбааг дүрсэлж, тухайн ажиллагааны товч нэр /англи хэлээр/ бичсэн байна



Бэлгийн уут

Метал хийцтэй, гэрэгэ хэлбэртэй, урт 7,5 см, өргөн 3 см, зузаан 2 мм, нэг талдаа ойн логоны дүрслэлтэй, хайрцагтай



Бэлгийн уут нь 20 жилийн ойн логог гадна талуудад дүрсэлсэн, чанар сайтай бариултай, 40 см-ийн өндөртэй

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ "ХАТАН ИЖИЙ" НАР ТОДОРЛОО



Зэвсэгт хүчний Жанжин штаб, Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулга хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Зэвсэгт хүчний "Хатан ижий" өргөмжлөлийн эзэд тодорлоо.

Энэхүү ёслол хүндэтгэлийн арга хэмжээ нь Зэвсэгт хүчинд олон жил хүчин зүтгэсэн, олон хүүхэд төрүүлж өсгөсөн, үр хүүхдүүд нь удам дамжин төрийн цэргийн байгууллагад ажилладаг ээжүүдийг тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу тодруулдаг бөгөөд гэр бүл,

үр хүүхдүүд, мөрдөстэй алба хаагчдаараа бахархах, иргэн цэргийн харьцааг бэхжүүлэх зэрэг томоохон ач холбогдолтой юм.

Өнөө жилийн "Хатан ижий" өргөмжлөлийн эздээр ЭХЖШ-ын Ахмадын хорооноос нэр дэвшүүлсэн Б.Загдсүрэн, ҮБХИС-иас нэр дэвшүүлсэн Ц.Алтанцэцэг, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлээс нэр дэвшүүлсэн Г.Оюунчимэг, Зэвсэгт хүчний 011 дүгээр ангиас нэр дэвшүүлсэн Л.Цэдээ, Зэвсэгт хүчний 089 дүгээр ангиас нэр дэвшүүлсэн Д.Алтанцэцэг,

Зэвсэгт хүчний 234 дүгээр ангиас нэр дэвшүүлсэн Б.Отгон, Зэвсэгт хүчний 311 дүгээр ангиас нэр дэвшүүлсэн Н.Халиун, Батлан хамгаалахын төв архиваас нэр дэвшүүлсэн Д.Цэнд, Зэвсэгт хүчний 119 дүгээр ангиас нэр дэвшүүлсэн С.Нэргүй нар тус тус тодорлоо.

Зэвсэгт хүчний "Хатан ижий"-гээр тодорсон ээжүүдэд хүндэтгэл үзүүлэн алдаршуулах ёслолын арга хэмжээ ирэх 3 дугаар сарын 2-ны өдөр зохион байгуулагдана.